



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 5/37

Хэрлэн сум

Түр орлон гүйцэтгэгч томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.15, 30.1.16, 2014 оны "Төрийн зарим албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай" 75 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Галшар сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал Н.Таня нь өндөр насны тэтгэвэр авах эрх үүсч, ажлаас чөлөөлөгдсөн тул 2017 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн тус сургуулийн багш О.Баярмааг сургуулийн захирал томилогдох хүртэл түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

Хоёр. Сургуулийн захирлын ажлыг хүлээлцэх комисс томилон хүлээлцүүлэхийг сумын Засаг дарга /Б.Энхтайван/-д даалгасугай.

Гурав. Сургуулийн захирлын түр орлон гүйцэтгэгчээр томилогдож байгаа О.Баярмаагийн цалинг ТҮБД-н 7-ын 1 дүгээр шатлал /673849/ төгрөгөөр тогтоож, цалинжуулахыг сургуулийн нягтлан бодогч /Л.Оюунжаргал /-д зөвшөөрсүгэй.

Дөрөв. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс / Г.Лхагвахатан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА